



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар 1/3

Өлгий

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/267 тоот захирамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын аймгийн Засаг даргатай 2022 онд байгуулсан хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны төсөвт тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах 2000000 /хоёр сая/, нөхөрлөлүүдэд дэмжлэг үзүүлэх чадавхжуулах сургалт зохион байгуулах 3000000 /гурван сая/, байгууллагын веб сайт, цахим мэдээллийг шинэчилэх 500000 /таван зуун мянга/, биотехникийн арга хэмжээ 8000000 /найман сая/, Чихэртэй голын байгалийн цогцолборт газарт биотехникийн арга хэмжээ авах 2000000 /хоёр сая/, Монгол Алтай нурууны улсын тусгай хамгаалалттай газарт ойжуулалт хийх 3000000 /гурван сая/, нийт 18500000 /арван найман сая таван зуун мянга/ төгрөг зарцуулахыг нягтлан бодогч /Х.Тилеухан/-д зөвшөөрсүгэй.

2. Дээрхи арга хэмжээний ажлыг зохион байгуулах, гэрээ хийж гүйцэтгэлд хяналт тавьж дүгнүүлж ажиллахыг холбогдох хариуцсан мэргэжилтэнүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА

Ш.МАРАТ

нд

га

лт

тэг

эл

эл

йн

ол

эн

ы

лд

хэ